



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 06 сарын 21 өдөр

Дугаар А/370

Алтай хот

Газар эзэмших эрхийн дуудлага
худалдаа зохион байгуулах ажлын хэсэг
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын 9.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2022 оны А/295 дугаар захирамжаар зарлагдсан газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдаа зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Ажлын хэсгийн дарга: Д.Гаадамба (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Газрын удирдлагын хэлтсийн дарга)

Гишүүдэд: Б.Золжаргал (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)
Ж.Мөнхчимэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Б.Бямбадорж (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга, ерөнхий архитектор)

Нарийн бичгийн дарга: Д.Мөнхтуяа (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн)

2.Газар эзэмших эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг журмын дагуу зохион байгуулж, шалгаруулалтын үр дүнг танилцуулахыг комисс (Д.Гаадамба)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Б.Хурцгэрэл)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР